

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөгт хадгалагдаж буй
Далай гүнгийн хошуунд холбогдох эх хэрэглэгдэхүүний тойм

Хэл зохиолын хүрээлэнгийн үе үеийн эрдэмтэд 1952-1992 оны хооронд жил бүр Монгол улсын аймаг, сумдаар хээрийн шинжилгээний анги илгээж монгол аман зохиол, нутгийн аялгууг судалсны үр дүнд монгол хэл бичиг, аман зохиол, түүх угсаатны зүйн холбогдолт баялаг эх хэрэглэгдэхүүн цуглуулсан билээ. Эдүгээ Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй 450 хавтас бүхий хээрийн шинжилгээний ангийн тайлан, гар бичмэл эх хэрэглэгдэхүүнээс шүүн үзэж Түшээт хан аймгийн Далай гүнгийн хошуунд холбогдох хэдэн материал олсноо бид тойм байдлаар танилцуулахаар бэлдлээ.

Юун түрүүн бид Өвөрхангай аймгаар явсан шинжилгээний ангийн тайлан² материалын тоог гарган, хавтаст материалуудын дугаар, хээрийн шинжилгээгээр явсан он, нэр зэргийг жагсаан хүснэгтэллээ³. Энд анхаарууштай нь, сан хөмрөгт хадгалагдаж буй хэд хэдэн тайлан материалд шинжилгээний ангийн бүрэлдэхүүн, гишүүдийн нэр зэрэг нь бичигдээгүй байхаас гадна зарим эх хэрэглэгдэхүүнд үүсгэгчийн нэр, нас, харьяаны талаар дурдалгүй орхисон, мөн олон оныг дамнан хадгалагдахдаа гээгдэн үрэгдсэн нь ч тохиолдож байна⁴.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй
Өвөрхангай аймгийн хавтаст материалын жагсаалт

№	Хавтасны дугаар	Он	Хавтаст материалын нэр
1	167	1964	Өвөрхангай аймагт явсан шинжилгээний ангийн цуглуулга Шинжилгээний ангийн ахлагч У.Загдсүрэн
2	194	1983	Өвөрхангай аймагт явсан шинжилгээний ангийн тайлан I Шинжилгээний ангийн ахлагч Л.Хүрэлбаатар
3	404	1983	Өвөрхангай аймагт явсан шинжилгээний ангийн материал II Шинжилгээний ангийн ахлагч Л.Хүрэлбаатар
4	217	1988	Өвөрхангай, Баянхонгор аймгийн шинжилгээний ангийн тайлан

Хүснэгт 1.

Дээрх хүснэгтэд жагсаасанчлан 1964, 1983, 1988 онуудад Өвөрхангай аймгаар явсан шинжилгээний ангийн нийт тайлан материал доторх маршрутыг ажиглаж, Далай

¹ ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторийн эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан М.Билгүүнчимэг

² Алимаа А, Катуу Б нар., *Монгол аман зохиол, нутгийн аялгууны хөмрөгийн бүртгэл*. I боть. УБ., 2004. 25т.

*Хөмрөгийн бүртгэлд дурдсанаар нийт 35 анги хээрийн шинжилгээгээр явсан хэмээжээ.

³ Хүснэгт 1

⁴ Билгүүнчимэг М., *ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй торгууд судлалд хамаарах эх хэрэглэгдэхүүний тойм*. Торгуудын түүх, шашин, өв соёл олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2023:150-161.

гүнгийн хошууны⁵ харьяат сумдаас цуглуулсан эх хэрэглэгдэхүүнүүдийг шүүн үзсэнээ та бүхэнд тоймлон хүргэе.

1964⁶ онд Өвөрхангай аймгаар явсан хээрийн шинжилгээний ангийн маршрутыг дурдъя. Батлагдсан арга зүйн дагуу хангайн бүс болох Өвөрхангай аймгийн Хархорин сум сангийн аж ахуй, Хужирт, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Уянга зэрэг сум; хангай говийн завсрын бүс болох Арвайхээр хот, Дэлгэрэх, Нарийнтээл, Өлзийт, Зүйл зэрэг сум; говийн бүс болох Баянтээгийн нүүрсний уурхай, Баруунбаян-Улаан, Богд, Гучин ус зэрэг 16 сум нэгдлийн нутгаар 44 хоногийн хугацаанд 3200 км аялж, орон нутгийн 300 гаруй ард иргэдтэй биечлэн уулзаж, ардын аман зохиол, нутгийн аялгуу, түүх уран зохиолын болон бусад төрлийн холбогдолтой ном судар хайж сурвалжлан судалсан байна. Шинжилгээний анги 4 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд ардын аман зохиолыг ахлагч У.Загдсүрэн, нутгийн аялгууг З.Төмөрцэрэн, ном судар сурвалжлах ажлыг Ч.Алтангэрэл нар тус тус хариуцан жолооч Самбуудорж ГАЗ-69 машин жолооджээ. 1964 оны тус тайлан материалд болон 1988⁷ оны 217 дугаар бүхий хавтаст материалд Далай гүнгийн хошуунд холбогдох эх хэрэглэгдэхүүн, тэмдэглэл байсангүй. Хэдий тийм боловч Баян-Өндөр сум аяллын маршрутад нь орсон байна.

1983 оны 194 дугаар бүхий хавтаст материал⁸ нь кирилл бичгийн машин болон гар бичмэлээр бичигдсэн 199 нүүр хуудас эх хэрэглэгдэхүүнээс бүрдэж байна. Тус шинжилгээний анги нь Өвөрхангай аймагт амьдардаг төв халхчуудын дунд өргөн дэлгэрсэн, тэдний ахуй амьдрал, зан заншлын онцлогийг тусгасан аман зохиолын бүх төрлүүдийг сурвалжлан судлахаар тусгай арга зүй боловсруулан эрдмийн зөвлөлийн хурлаар батлуулж 9-р сарын 13-аас 10-р сарын 5-ны өдрийг хүртэл нийт 23 хоног ажиллажээ. Шинжилгээний ангийн ахлагчаар эрдэм шинжилгээний дэд ажилтан Л.Хүрэлбаатар, бүрэлдэхүүнд нь О.Алимаа, Л.Чулуунбат нар УАЗ-469 машинаар 2500 орчим км явж, Өвөрхангайн говь, хээр тал, хангайн 15 сум, сангийн аж ахуйн нутаг дэвсгэрийг хамарч судалгаа хийжээ. Судалгааны дүнд үлгэр 21, дуу 50 орчим, ерөөл магтаал 15, морь бөхийн цол 11, оньсого, зүйр цэцэн үг 78, зан үйлийн холбогдолтой аман зохиолын бусад жижиг төрөл болох эсгий хийх, хүүхэд угаахад хэлдэг бэлгэ дэмбэрлийн үгс, шатрын хожлын үг, даалууны гуншин, таван хурууны нэр зэрэг 7, домог үлгэр 9, домог хууч яриа 22-ыг цуглуулж, нийт 15 орчим хэвлэлийн хуудас материалыг гар бичмэл эхээр бичиж тэмдэглэн, мөн соронзон хальснаа буулгасан байна.

1983 онд Өвөрхангай аймгийн нутгаар явсан дээрх шинжилгээний ангийн тайлан, цуглуулгыг 2 хавтсанд хадгалж төрөлжүүлсэн бөгөөд 404 дугаар бүхий 2 дахь хавтаст

⁵ <https://mongoltoli.mn/history/h/602>

⁶ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас X-5 T-25 №167 1964 онд Өвөрхангай аймагт явсан шинжилгээний ангийн цуглуулга.

⁷ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас X-8 T-12 №217 1988 онд Өвөрхангай, Баянхонгор аймгаар явсан шинжилгээний ангийн тайлан.

⁸ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас X-5 T-51 XH 1-70 №194 1983 онд Өвөрхангай аймагт ажилласан шинжилгээний ангийн тэмдэглэсэн хэрэглэгдэхүүн I.

материал⁹ нь 336 нүүр хуудас гар бичмэл эх хэрэглэгдэхүүнээс бүрдэж байна. Далай гүнгийн хошуунд холбогдох нэгжүүдээс дурдвал:

- Өвөрхангай аймгийн Бүрд сумын харьяат 83 настай эрэгтэй Гомбын Лувсанцэрэн “Хоёр монгол хангайн магтаал” /67-69/, “Эх орны магтаал (аймгийн)” зэргийг /72-79/ 1983 оны 10-р сарын 20-нд ЭША А.Алимаад тэмдэглүүлжээ.
- Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын төвийн 73 настай эмэгтэй Л.Норов 7 ширхэг оньсогыг, хариултын хамт /90/ бичүүлжээ.
- Өвөрхангай аймгийн Бүрд сумын төвийн 80 настай эрэгтэй Дулзангийн Дарьбазар 5 ширхэг оньсогыг, хариултын хамт /91/ бичүүлжээ.
- Өвөрхангай аймгийн Бүрд сумын төвийн 99 настай эрэгтэй Дэжидийн Тавхай гурван төрлийн домог /136-139/ бичүүлжээ. Үүнд, “Тотгоолжийн долоо хүү”, “Доной баян”, мөн “Ертөнцийн үүслийн тухай”-т зэрэг төдийлөн тархаагүй домог үлгэрүүдийг хэлж тэмдэглүүлжээ.
- Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын төвийн 89 настай эмэгтэй Ж.Жаргал нэгэн домог /140-141/ тэмдэглүүлжээ.
- Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын “Саруул зам” нэгдлийн гишүүн Жамцын Төрмөнх “Борооны тухай шог дуу¹⁰” дуулж, “Богдын тухай магтаал¹¹” аялгуулан хэлж бичүүлсэн нь тус хүрээлэнгийн соронзон хальсны хөмрөгт дижитал хэлбэрээр хадгалагдаж байна.

Тус хээрийн шинжилгээний ангийн 194 дугаар бүхий хавтаст материалын үлгэр туулийн тайлангийн хэсэгт “Хэдэн жилийн өмнө Баян-Өндөр сумын нутгаас олдсон “Алтан галуу ноён” гэдэг туулийн мөрийг түүнтэй зэргэлдээ Баянгол, Бүрд, Өлзийт, Зүйл болон бусад сумын нутгаас сурвалжлахад мэдэх, ярих хүн үгүй байлаа” хэмээн бичсэн байна. Тухайн тэмдэглэлд түшиглэн бид уг туулийг хүрээлэнгийнхээ сан хөмрөгөөс шүүж, соронзон хальсны 2 бичлэг, бичмэл дөрвөн хувилбарыг шүүрдэн үзэв. Мөн Хэл зохиолын хүрээлэнгээс 1967¹², 1991¹³ онуудад хэвлүүлсэн “Халх ардын тууль” болон 2013¹⁴ оны “Халх тууль” зэрэг номд дурдсан “Алтан ноён галуу хүү” туулийн мэдээлэл, хувилбаруудыг дансны дугаараар нь тулган үзэхэд тохирч байна.

Тодруулбал, Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид “Алтан галуу ноён” туулийн дараах хувилбарууд хадгалагдаж байна.

⁹ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас X-5 T-51 ХН 71-131 №404 1983 онд Өвөрхангай аймагт явсан шинжилгээний ангийн материал II.

¹⁰ Эх хэл бичгийн сан хөмрөг. Соронзон хальс 531b-11-06.

¹¹ Эх хэл бичгийн сан хөмрөг. Соронзон хальс 531b-12-10.

¹² Лувсанвандан С, Загдсүрэн У нар., *Халх ардын тууль*. Ред Хорлоо П. УБ., ШУАХ, 1967:253.

*Уг номд Архангай, Өвөрхангай зэрэг төв халхын нутгаас тэмдэглэсэн найман туулийг хэвлүүлжээ.

¹³ Нарантуяа Р нар., *Халх ардын тууль*. Ред Сампилдэндэв Х. УБ., УХГ, 1991:171.

*Уг номд Архангай, Өвөрхангай зэрэг төв халхын нутгаас тэмдэглэсэн арван гурван туулийг хэвлүүлжээ.

¹⁴ *Халх тууль*. Ред Катуу Б. УБ., Соёмбо принтинг, 2013:408. ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний Комиссоос эрхлэн гаргасан.

*Уг номд төв халхын нутгаас тэмдэглэсэн найман туулийг хэвлүүлжээ.

1. Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын “Саруул зам” нэгдлийн 3-р бригадын 54 настай эмэгтэй Хөхөөгийн Ичинхорлоо “Алтан ноён галуу хүү¹⁵” туулийг аялгуулан хэлж, Хэл зохиолын хүрээлэнгийн шинжилгээний нэгэн ангийн соронзон хальсанд бичүүлснээр 42а-1 дугаартай бичлэг хөмрөгийн санд хадгалагдан үлджээ. 1967, 1991 оны “Халх ардын тууль”, 2013 оны “Халх тууль” ном болон 1983 онд Өвөрхангай аймагт явсан шинжилгээний ангийн тайлан материал хийгээд 2004 онд Хэл зохиолын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлсэн “Монгол аман зохиол, нутгийн аялгууны хөмрөгийн бүртгэл”-д уг бичлэгийн эх сурвалж дурдагдаагүй байна. Иймээс бид 42а-1 дугаартай соронзон хальсны бичлэгийн эх нь 1973 онд Хэл зохиолын хүрээлэнгээс Төв, Дундговь аймгийн зарим сумд ардын аман зохиол, нутгийн аялгуу судлахаар явсан шинжилгээний ангийн тайлан бүхий 173 дугаар бүхий хавтаст материалд хадгалагдаж байсныг шүүн оллоо.

1973 оны 173 дугаар бүхий хавтаст материал¹⁶ нь кирилл бичгийн машин болон гар бичмэлээр бичигдсэн 225 нүүр хуудас эх хэрэглэгдэхүүнээс бүрдэж байна. Тус шинжилгээний анги нь Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн 1973 оны 7-р сарын 13-ны өдрийн хурлаар батлагдсан арга зүйг баримтлан 1973 оны 7-р сарын 20-оос 8-р сарын 19-ийг дуустал 30 хоногийн хугацаатайгаар Төв аймгийн Эрдэнэсант, Өндөрширээт, Бүрэн, Дэлгэрхаан, Баянбараат, Баян, Баянцагаан, Баянжаргалан, Мөнгөнморьт, Дундговь аймгийн Луус зэрэг арван сум нэгдлийн зуу гаруй суурь өрхөөр явж ардын аман зохиол, нутгийн аялгуу, хуучин ном судрын зүйлийг сурвалжлан цуглуулжээ. Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд аман зохиол судлалын Д.Цэрэнсодном, Ч.Сэрээнэндорж, Д.Дашдорж, хэл шинжлэлийн Ц.Шагдарсүрэн нар явж, ГАЗ-53 машины жолоочийн хамт 2500 км замыг туулан ажиллажээ. “Алтан галуу ноён хүү” туулийг тайлан материалын “Явган үлгэр” хэсэгт оруулан дурдахдаа үүсгэгчийг Төв аймгийн Дэлгэрхаан сум нэгдлийн Бурамын Ичинхорол¹⁷ хэмээн тэмдэглэсэн байна. Дэлгэрхаан сум нь Төв аймгийн баруун хойд хэсэгт байрлаж, Төв аймгийн Бүрэн, Эрдэнэсант, Дундговь аймгийн Эрдэнэдалай сум болон Өвөрхангай аймгийн Баян-Өндөр, Бүрд гэсэн 5 сумтай хиллэдэг аймгийн захын сум¹⁸ ажээ. Үүнээс дүгнэвэл шинжилгээний ангийнхан очих үеэр Бурамын Ичинхорол гуай залгаа сумын нутагт бууриа сэлгэн нутаглаж байсантай холбоотойгоор Өвөрхангай аймгаар явсан шинжилгээний гурван ангийн тайлан материалаас 42а-1 дугаартай бичлэгийн үүсгэгчийн мэдээлэл олдоогүй бололтой. Харин соронзон хальсыг тоглуулбал, бичлэгийн эхэнд: *Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын “Саруул зам” нэгдлийн Хөхөө гуайн буюу 3-р бригадын харьяат Бурамын Ичинхорлоо гуай. Энэ жил нас 54,*

¹⁵ Эх хэл бичгийн сан хөмрөг. Соронзон хальс 42а-1.

¹⁶ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас Х-5 Т-31 №173 1973 онд Төв, Дундговь аймгийн зарим сумд ажилласан шинжилгээний ангийн цуглуулга.

¹⁷ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас Х-5 Т-31 №173 1973 онд Төв, Дундговь аймгийн зарим сумд ажилласан шинжилгээний ангийн цуглуулга.

¹⁸ touristinfocenter.mn

эмэгтэй. “Алтан ноён галуу” гэдэг үлгэр хэлнэ ээ¹⁹ хэмээн тухайн судлаач үүсгэгчийг нь тодорхой зарласан байна.

Туулийн агуулгыг хураангуйлбал,

Арван найман настай Алтан ноён галуу хүү гэж нэгэн сайн эр байжээ. Аваасаа унадаг сайн морь, авдагхан сайн авгайгаа асууж гэнэ. Ингээд хуйваар барьдаггүй, хурайлж нэгэн барьдаг ам цагаан хул морио даллаж нэгэн дуудсанд олон адуунаасаа онцгойрон давхиж ирэв. Мордоод жир жирхэн хатиргаад жингэнэтэл исгэрч давхиулсаар оосор бүч үгүй орд цагаан өргөөнд ирж долоон насандаа долгилонхон төрсөн, Дотор Бээжин хоёрыг эзлэнхэн төрсөн, гурван төрлөө мэдэх гундан ягаан хацартай, туурга нэвт туяарсан тунсаг ягаан хацартай Хан Чингис хааны Хар нүдэн авайг авна гэдгээ хэлэв. Тэгтэл хаан, хатан хоёр тэмээн чинээ толгойтой том хар мангас аваад явчихсан гэж хэлээд хүүг ерөөгөөд явуулна. Алтан ноён галуу хүү алтан бялзуухайд хувилан мангасын гэрийн тоонон дээр суугаад харвал мангас “Халхад надаас сайн эр байхгүй, арван найман настай Алтан ноён галуу хүү гэдэг надаас ганцхан хэрчим илүү” гэж барын чинээ бараан гуяаа алгадаж бар бар инээд алдан баруун хойд талаа эзлэн суудаг. Хан Чингис хааны Хар нүдэн авай энтэй торгыг шаглаж, энгүй торгыг захалж зүүхэн урд талд суухдаа тооно руу харан инээд алдана. Ингээд Алтан ноён галуу хүүгийн уур нь хүрч түмэн хүн айх түүхий улаан царайгаа гарган орж, амар мэнд асуун очно. Мангас “Маргаашийн мандах улаан наранд Уулзахын улаан хөтөл, Болзоотын бор толгой хоёрт улаан цайгаа уулцъя, аль л дийлсэн нь авъя” гэж хэлдэг. Мангас мандах улаан нарнаар Уулзахын улаан хөтөл дээр гарч ирэн Болзоотын бор толгой дээр буй хүүгээс хэн эхэлж харвахыг лавладаг. Ийнхүү мангас ширмэн булцуут даргай хар нумаараа түрүүнд харвахад Алтан ноён галуу хүүгийн цээжин дээр буудаг. Алтан ноён галуу хүү нь хандгай бугын ширийг ханзлал үгүй хийсэн, хангардийн өдийг таслал үгүй тавьсан даргай хар нумыг таттал мангасын цээж бөгсөөр нэвтлэн гарна. Гэвч мангас хойд уулаа авч хойд сорвио бөглөчхөөд, урд уулаа авч урд сорвио бөглөчхөөд, хар хадгаар хав хийтэл нь ороочхоод, шар хадгаар шав хийтэл нь ороочхоод өмнөө байсан уулаар тэвэг өшиглөнхөн айсуу. Алтан ноён галуу хүү “Одоо энийг чинь яадаг юм билээ” хэмээх үед ээж аав хоёр нь “Миний хүү ширээн дээрээс шилжжээ, ширдэг дээрээс гулгажээ” гэж зөнтэй зүүдлэн хонож ахад нь хэлнэ. Ах нь Уушилдай хүү Шуушилдай мэргэн Болзоотын бор толгой дээр эмээл ч үгүй зайдан яаран гарч, жилэвчлэн харж жилийн газрыг харахад гурван жилийн тэртээ уул гэтэл уул биш юм байхаар нь “Мангасын амин газраар орох болтугай” хэмээн шившиж харвадаг. Мангас ойчин унаж Алтан ноён галуу хүүгээс өршөөл эрдэг ч хүү толгойг нь тас цавчин мориндоо молцог хийн мордоно. Ийнхүү ах дүү хоёул мангасын нутаг орныг олзлон буцаж амар сайхандаа жаргажээ.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн сан хөмрөгт халх туулийн олон эх хадгалагдаж буйн нэг нь энэхүү тууль билээ. Халхчууд туулийг үлгэр гэж нэрлэх ба

¹⁹ Эх хэл бичгийн сан хөмрөг. Соронзон хальс 42a-1.

жирийн үлгэрийг явган үлгэр гэх нь элбэг²⁰. “Тууль” гэдэг үгийг төлөв баруун монгол, буриадын зарим нутагт хэрэглэн мангас буюу эзэрхэг хаан, баатартай тулалдсан эрэлхэг эрийн тухай үлгэрийг тийн нэрлэж, түүнийг уран сайхнаар аялгуулан эгшиглэдэг хүнийг “туульч” гэдэг байна. Халх, мөн буриад, өвөрлөгчид зэрэг бусад нутагт “тууль” гэдэг үгийг төдий л үл хэрэглэн ер “үлгэр” буюу “урт үлгэр”, “хууч үлгэр” гэх бөгөөд түүнийг хэлдэг хүнийг “үлгэрч” буюу “урт үлгэрч” заримдаа “хуурч” ч гэж нэрлэх нь бий²¹. Бид Далай гүнгийн хошуунд хамаарах энэхүү “Алтан ноён галуу хүү” туулийн соронзон хальсны бичлэгийг Хэл зохиолын хүрээлэнгийн соронзон хальсны хөмрөгөөс зөвшөөрөл бичгийн дагуу сонсож буулгахдаа 173 дугаар хавтаст материалд буй Хөхөөгийн Ичинхорлоо гуайн аялгуулан хэлсэн “Алтан галуу ноён” туулийг буулгасан гар бичмэлтэй²² харьцуулан тулгаж, ямар нэгэн засвар оруулалгүй Хөхөөгийн Ичинхорлоо гуайн аялгуулан хэлсэн янзаар кирилл бичигт буулган хавсаргалаа.

2. Өвөрхангай аймгийн түмтийн дарга Дүгэр овогтой ахлах дэслэгч Лүндаажанцангийн²³ тэмдэглүүлсэн “Алтан ноён галуу хүү гэгч үлгэр²⁴” хэмээх 19 нүүр хуудас бүхий монгол бичгийн гар бичмэл хувилбар. Энэхүү Өвөрхангай аймгийн хувилбарыг хэдэн онд, хэн тэмдэглэн авсан нь тодорхойгүй байна.

Туулийн агуулгыг хураангуйлбал,

Арван таван настай Алтан ноён галуу хүү хаан аав ээжийндээ ороод унах сайн морь, авдаг сайн авгайгаа асуудаг. Хаан Чингист хааны Хар нүдэн авхайг авахаар ам цагаан хул морио унаад очтол тэмээн чинээ толгойтой том хар мангас аваад явчихсан байдаг. Уг туульд ам цагаан хул морь нь Алтан ноён галуу хүүд чи бид 2 зүсээ өөрчилье гэж зөвлөж хэлнэ. Алтан ноён галуу хүү өөрөө алтан болжмор болж, ам цагаан хул морио мөнгөн болжмор болгоод мангасын гэрийн тоонон дээр нисэж очоод буутал тэмээн чинээ толгойтой том хар мангас гэрийнхээ баруун хойд талыг эзэлж барын чинээ гуяаа нэг, хоёр алгадаж бар бар инээж сууна. Хаан Чингист хааны Хар нүдэн авхай нь гэрийн зүүн урд талыг эзэлж энтэй торгыг шаглаж, энгүй торгыг захалж сууж байхдаа дээшээ хараад алтан, мөнгөн болжморыг ажиглаж инээтэл мангас хатнаас “Чи хоёулаа суусаар атал юунд инээж байна вэ?” хэмээн асуудаг. Тэгэхээр хатан нь “Халхад чамаас илүү сайн эр байдаг болов уу гэж инээд хүрч байна” гэтэл мангас “Халхад надаас илүү сайн эр байхгүй. Гагцхүү арван таван настай Алтан ноён галуу хүү гэдэг надаас ганц хэрчим илүү бололтой юм билээ” гэхэд нь Алтан ноён галуу хүү түмэн хүн айдаг түүхий улаан царайгаа гаргаж мангасынд орж очоод маргааш өглөөний өөд улаан нарнаар Уулзахын улаан хөтөл, Болзоотын бор толгой хоёр дээр улаан цайгаа уулцаж аль дийлсэн нь Хар

²⁰ Лувсанвандан С, Загдсүрэн У нар., *Халх ардын тууль*. Ред Хорлоо П. УБ., ШУАХ, 1967. 3т.

²¹ *Монгол ардын баатарлаг туульс*. Аман зохиол цуврал, Боть-1, дэвтэр-7. Эмхэт Ринчинсамбуу Г. УБ., УХГ, 1960. 3т.

²² Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөгийн 173 дугаар хавтаст материалд Хөхөөгийн Ичинхорлоо гуайн аялгуулан хэлсэн “Алтан галуу ноён” туулийг буулгасан гар бичмэл хадгалагдаж буйг бид шүүн оллоо.

*Энэ гар бичмэлийн төгсгөлд 1973-7-30 Д.Дашидорж 3-р дамрын 2-р талын 1-ээс буулгаж бичив. Төв, Дэлгэрхаан, Дуутын хар чулуу хэмээн тэмдэглэсэн байв.

²³ 1991 оны “Халх тууль” номд Лүндэнринчин хэмээн буулгасныг бид Лүндаажанцан хэмээн сийрүүллээ.

²⁴ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас Х-2 Т-62 ХН 8 №94 Төрөлжүүлсэн хавтаст материал “Үлгэр”.

нүдэн авхайг авахаар бололцоно. Мангастай тохирсон ёсоор уулзаж харвалдаад, дийлж ядаж махбодоор үзэлцэж, гурван өдөр гурван шөнө ноцолдоод мангасыг далнаас нь барьж 73 эргүүлж гуянаас нь барьж 33 эргүүлж 7 гүвээг дамнуулж алаад 80 алд газар ухаж дээрээс нь Болзоотын бор толгойг тавиад мангасын аль байдгийг хурааж, орон нутагтаа ирж амар сайхандаа жаргаж гэнэ.

3. Хуучнаар Сайн ноён хан аймгийн Балдан засгийн хошуу, одоогийн Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 3-р бригадын 51 настай эрэгтэй Цэрэнгийн Шарав “Зүүн гурван тивийг эзлэн төрсөн Алтан ноён Галуухай хаан²⁵” хэмээх хувилбарыг 1961 онд судлаач Домийн Төмөртогод²⁶ хэлж тэмдэглүүлсэн байна. Энэ үлгэрийг Мэргэн вангийн хошууны Цэндээс сурчээ. 20 нүүр хуудас бүхий энэхүү хувилбар кирилл гар бичмэлээр 89 дүгээр хавтаст материалд хадгалагдаж байна.

Туулийн агуулгыг хураангуйлбал,

Арван хэдэн настай Алтан Галуухай хаан хаан суусан аав, хатан суусан ээж, адууныхаа Агсгалдай өвгөн гуравт өдөр дараалж өглөө эртлэн очоод “Баруун гурван тивийг эзлэн төрсөн Бар арслан хааны хатан буурал эхийн гэдсэн дотор нь байхад нь сүй бэлгээ тавьсан хатан юугаа авъя” гэж хэлдэг ч “Нас чинь бага, цус чинь шингэн, цаг чинь болоогүй байна” гэсэн хариу авдаг. Тэгээд рашаан булгийнхаа эхэнд арван гурван сангаа тавихад халзан хонгор морь нь даллуулж харайн дүүлэн очиж, хүний хэлээр ярьж, ижил сүргээ ерөөдөг. Баруун зүгийг эзлэн төрсөн Бар арслан хааныд очтол хүүд бардам байдлаар “Дан цагаан дээлтэй дагир муу морьтой чам шиг муу хүү бүү хэл зуун мянган цэргээрээ би зургаан сар хөөлгөөд гүйцээгүй. Арван таван толгойтой атгаалжин хар мангас арван сарын өмнө аваад тонилсон. Жигүүртэн шувуу хүртэл жилээр хүрэхгүй газарт бий” гэж хэлнэ. Алтан Галуухай хүү энэ үгийг сонсоод гурван жилийн газрыг гурван цагаар товчилж одтой тэнгэрт оройгоороо тулсан оосор бүчгүй орд цагаан өргөөнд хүрч дайныг дарсан зандан хүрэн ташуураа бариад ороход арван таван толгойтой атгаалжин хар мангас “Өвөр дэхээ гэсэн өмнөхөө хөглүүлсэн өчүүхэн бор хүү чи хаа зорьж явна” гэж асууна. Тийнхүү Болзоотын бор толгой дээр гарч харвалдахад Алтан Галуухай хүүгийн сум нь атгаалжин мангасын цээжин дээр аянга болон дэлбэрээд арван дөрвөн толгой нь газарт өнхрөн унадаг. Үлдсэн ганц толгойгоороо мангас зугтаана. Мэргэн баатар хүү мангасыг дахин харваад хомхой мангасын гэдсийг ховх цоолон нээдэг. Олзлогдож очсон хатнаа аваад Бар арслан хааныд ирэхэд охины төлөөх эрийн гурван наадам болж Алтан ноён Галуухай хаан эхний гурван байрыг нь авч сүйт хатнаа аваад аавын үед байгуулсан алтан сайхан сүмдээ очиж амар сайхандаа жаргана.

4. Хэнтийн 7 дугаар багийн 34 настай эрэгтэй, халх Баяны Жанжаагийн тэмдэглүүлсэн “Алтан галуу ноён хан хүү²⁷” хэмээх 11 нүүр хуудас бүхий монгол бичгийн бичгийн машинаар шивсэн хувилбар. Энэхүү хувилбарыг хэдэн онд, хэн тэмдэглэн авсан нь мөн тодорхойгүй байна.

²⁵ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас Х-2 Т-56а ХН 4 №89 Төрөлжүүлсэн хавтаст материал “Үлгэр”.

²⁶ Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хэл бичгийн шинжлэх ухааны доктор, профессор, академич Домийн Төмөртогод

²⁷ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас Х-2 Т-54 ХН 62 №876 Төрөлжүүлсэн хавтаст материал “Үлгэр”.

Туулийн агуулгыг хураангуйлбал,

Уран могой ээжтэй Алтан галуу ноён хан хүү алтан чихтэй шарга морио бариулж “Аавын тайж явсан Алтан сүмбэр уулд арван гурван сангаа тавина” гэж морджээ. Тэгтэл Алтан сүмбэр уулын орой дээр Алтан овооны дэргэд ерэн тав, далан тав, арван таван толгойтой ах дүү гурван мангас зогсож байна. Тэд Алтан галуу ноён хан хүнийг алж Уран могой ээжтэй нь суух санаатай явж байгаа зүүн хойд тивийг эзлэн төрсөн ах дүү гурван мангас байдаг. Алтан галуу ноён хан хүү анхны мангас, далан таван толгойт хоёрыг алж, арван таван толгойт мангасын гуяны дунд чөмгийг хуга гуядаад хаздаг хар буураар дээрээс нь хэвтүүлээд харьдаг. Эхдээ захиас хэлнэ. Харин Уран могой ээж нь хойд уулын орой дээр битгий гараарай гэсэн гэж гараад арван таван толгойтой мангасыг аварч нөхрөө болгон үүрээд харина. Тэгээд аавын хайрласан 13 нүдтэй алтан шургуулгыг битгий уудлаарай гэсэн гээд уудалсанд үхсэн хүнийг босгодог эм гарч үхсэн мангасаа эдгээнэ. Алтан галуу ноён хан хүү ааваас хайрласан алтан дуулганыхаа оройг гялалзуулаад гэртээ орж иртэл мангастай хуйвалдан өвдсөн дүр эсгэж Галын хааны галзуу хар буурын голт зүрхийг авчруулахаар болно. Алтан галуу ноён хан галзуу хар буурыг тушиж байтал зүүн хойноос шар дээлтэй шарга морьтой лам шогшиж ирээд эр мангас, эм шулам хоёрын үгэнд ороогүй бол чи сайн хүү байна гэдэг. Тэгээд Галын хаан хүүд тусална. Алтан галуу ноён хан хүү гэртээ орж иртэл Уран могой ээж нь дахин мангастай хуйвалдан хүүгийнхээ аягын чинээ улаан мэнгийг илбэе гэж хэлээд хүүгээ алдаг. Алтан чихтэй шарга морь, гэсэр басар нохой, тонон дээр нь эргэдэг шувуу, буур бултаараа цуглараад хүний хэлээр хэлэлцдэг. Алтан чихтэй шарга морь нь Алтан галуу ноён хан хүүгийн гурван эгчид очиж хэлэхээр тэнгэрт гарна. Гурван дагинас, гурван алтан бумбатай рашаан авч морьтой дөрвүүл таван өнгийн солонго татуулж хүүгийн ясан дээр бууна. Бумбат рашаанаа гурвуул дусаасанд Алтан галуу ноён хан хүү дахин амилаад, мангасыг цавчиж, эхийгээ мөн алдаг.

5. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Долгорын Дэнцоогоос бичиж авсан “Алтан галуу ноён” туулийн ТАЗЛ 346-1-2 дугаартай соронзон хальсны бичлэг²⁸ хадгалагдаж буй гэх мэдээлэл байгаа ч уг хальс хатаж гэмтсэн тул сонсох боломгүй болжээ.
6. Барнайн Лхамсүрэнгийн үлгэрийн цуглуулгад буй “Алтан галуу ноён²⁹” хэмээх 11 нүүр хуудас бүхий кирилл бичгийн машинаар шивсэн хувилбар. Энэ хувилбарыг хэдэн онд, хэн тэмдэглэн авсан нь тодорхойгүй бөгөөд 1967 оны “Халх ардын тууль” номд дансны бүртгэл нь бичигдээгүйгээс үзвэл түүнээс хойно тэмдэглэсэн бололтой. Туулийн агуулгыг хураангуйлбал,

Баруун өмнө тивийг эзэлсэн Агь улаан хааны Алтан галуу ноён нь Амраг хайрын дээд Усан гилүүр хатантай, албат иргэдийн дээд алиа Дарам тайжтай, агт сүргийн дээд хурдан хул морьтой, аврал буяны дээд Арш цагаан ламтай. Усан гилүүр хатан нь шинийн нэгний шөнө шинж муутай зүүд зүүдэлсэнд шөнө босож Алтан галуу ноёндоо

²⁸ Нарантуяа Р нар., *Халх ардын тууль*. Ред Сампилдэндэв Х. УБ., УХГ, 1991. 170т.

²⁹ Эх хэл бичгийн сан хөмрөг. Хавтас Х-388, ХН 12 №388 Магнитофоноос буулгасан домог, үлгэр.

айлтгаж өчин мөргөнө. Агь улаан хаан харанхуй шөнийн зүүд нь хааш яаш байдаг гээд алиа Дарам тайжид хурдан хулыг унуулаад Арш цагаан мэргэн рүү алтан ембүү, алд шар хадгийн хамтаар бариулж явуулна. Арш мэргэн Алиа догшин баатарт асар түргэн оч гэж зөвлөнө. Алиа Дарам тайж хаандаа ирж айлтгахад алтан ембүү, алд шар хадгийн хамтаар бариулж Алиа догшин баатарт явуулдаг. Алиа догшин баатар хүний хэлээр ярьдаг их цагаан мориндоо даргай хар эмээлээ тохож, даргай хар нумаа авч, дайралтдаа цавчдаг дархан хар илдээ зүүж, буцалтдаа цавчдаг буруу хар илдээ зүүж, эргэлтдээ цавчдаг эргүү хар илдээ бариад мордоно. Болзоотын бор толгой дээр ургахын улаан нарнаар хүрээд очтол арван таван толгойтой атгаалжин хар мангас ирж Агь улаан хааны хүү Алтан галуу ноён гэдгийн амь биеийг нь алаад, авгай хүүхдийг нь авахаар явж байна хэмээнэ. Алиа догшин баатар, мангас хоёр харвалдахаар болж мангас урйтав. Алиа догшин баатар сумаа шившин харваж мангасын биеийг гурван хэсэг болгоно. Гурван талаас нь гурван шулам болоод дайрахад гурван хар илдээрээ алж дуусгана.

Дээрх “Алтан галуу ноён” туулийн соронзон хальсны 1 бичлэг, бичмэл дөрвөн хувилбарын өгүүлэмжийг хүснэгтээр³⁰ харьцуулан харуулья.

№	1	2	3	4	5
Туулийн нэр	Алтан ноён галуу хүү	Алтан ноён галуу хүү гэгч үлгэр	Зүүн гурван тивийг эзлэн төрсөн Алтан ноён Галуухай хаан	Алтан галуу ноён хан хүү	Алтан галуу ноён
Үүсгэгчийн нэр	Хөхөөгийн Ичинхорлоо	Дүгэрийн Лүндаажанцан	Цэрэнгийн Шарав	Баяны Жанжаа	Барнайн Лхамсүрэн
Үүсгэгчийн харьяалал	Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сум	Өмнөговь аймгийн Гурвантэс сум	Хэнтий аймаг	-	-
Бүртгэсэн судлаач	Д.Цэрэнсодном, Ч.Сэрээнэндорж, Д.Дашдорж	-	Домийн Төмөртоогоо	-	-
Он	1973	-	1961	-	-
Баатрын нэр	Арван найман настай Алтан ноён галуу хүү	Арван таван настай Алтан ноён галуу хүү	Арван хэдэн настай Алтан Галуухай хаан	Уран могой ээжтэй Алтан галуу ноён хан хүү	Агь улаан хааны Алтан галуу ноён
Сүйт авхайн нэр	Долоон насандаа долгилонхон төрсөн, Дотор Бээжин хоёрыг эзлэнхэн төрсөн Хан Чингис хааны Хар нүдэн авай	Хаан Чингист хааны Хар нүдэн авхай	Баруун гурван тивийг эзлэн төрсөн Бар арслан хааны хатан буурал эхийн гэдсэн дотор нь байхад нь сүй бэлгээ тавьсан хатан	-	Амраг хайрын дээд Усан гилүүр хатан шинж муутай зүүд зүүдэлсэн
Хүлэг морь	Ам цагаан хул морь нь хурайлан даллуулж ирдэг ч хурайлан даллуулж ирдэг ч хүний хэлээр ярьдаггүй	Ам цагаан хул морь нь хурайлан даллуулж ирдэг ч хүний хэлээр ярьж, зүсээ өөрчилье гэж Алтан ноён галуу хүүд зөвлөдөг	Рашаан булгийнхаа эхэнд арван гурван сангаа тавихад халзан хонгор морь /алтан шаргал морь/ нь даллуулж ирдэг ч хүний хэлээр ярьж, ижил сүргээ	Алтан чихтэй шарга морь, гэсэр басар нохой, тоонон дээр нь эргэдэг шувуу, буур бултаараа цуглараад хүний хэлээр хэлэлцдэг.	Агт сүргийн дээд хурдан хул морь; Хүний хэлээр ярьдаг их цагаан морь

³⁰ Хүснэгт 2.

			ерөөдөг.	Алтан чихтэй шарга морь нь Алтан галуу ноён хан хүүгийн гурван эгчийг туслуулахаар тэнгэрт гарна.	
Хувилал	Алтан ноён галуу хүү алтан бялзуухайд хувилдаг	Алтан ноён галуу хүү алтан болжмор болж, ам цагаан хул морио мөнгөн болжмор болгодог	-	-	-
Мангас	Мангасыг цээж, бөгсөөр хуваахад тоолгүй уулыг аван шархаа бөглөдөг	Мангасыг цээж, бөгсөөр хуваахад тоолгүй уулыг аван шархаа бөглөдөг	Арван таван толгойтой атгаалжин хар мангас	Зүүн хойд тивийг эзлэн төрсөн ерэн тав, далан тав, арван таван толгойтой ах дүү гурван мангас	Арван таван толгойтой атгаалжин хар мангас
Болзох газар	Уулзахын улаан хөтөл, Болзоотын бор толгой	Уулзахын улаан хөтөл, Болзоотын бор толгой	Болзоотын бор толгой	Аавын тайж явсан Алтан сүмбэр уулын орой дээрх Алтан овоо	Болзоотын бор толгой
Харвалдаан	Мангас эхэлж харвадаг	Мангас эхэлж харвадаг	Алтан Галуухай хүүгийн сум нь атгаалжин мангасын цээжин дээр аянга болон дэлбэрээд арван дөрвөн толгой нь газарт өнхрөн унадаг.	-	Мангас эхэлж харвадаг Алиа догшин баатар мангасын бисийг гурван хэсэг болгоно.
Биеийн хүч	-	Мангастай махбодоор үзэлцэж, гурван өдөр гурван шөнө ноцолдоод мангасыг далнаас нь барьж 73 эргүүлж гуянаас нь барьж 33 эргүүлж 7 гүвээг дамнуулж алаад 80 алд газар ухаж дээрээс нь Болзоотын бор толгойг тавьдаг	Эрийн гурван наадам гэж дурдаад өнгөрнө	Алтан галуу ноён хан хүү анхны мангас, далан таван толгойт хоёрыг алж, арван таван толгойт мангасын гуяны дунд чөмгийг хуга гуядаад хаздаг хар буураар дээрээс нь хэвтүүлээд харьдаг	Алиа догшин баатрын гурван талаас гурван шулам болоод мангас дайрахад дайралтдаа цавчдаг дархан хар илд, буцалтдаа цавчдаг буруу хар илд, эргэлтдээ цавчдаг эргүү хар илдээрээ алж дуусгана.
Туслах баатар	Ах нь Уушилдай хүү Шуушилдай мэргэн	-	-	Галын хаан /шар дээлтэй шарга морьтой лам/ Гурван дагина /Алтан галуу ноён хан хүүгийн эгч дүү нар нь/	Албат иргэдийн дээд алиа Дарам тайж; Аврал буяны дээд Арш цагаан лам; Баруун хойд тивийг эзэлж долоон насандаа догдлуулан эхэлсэн, Дотор Бээжин хоёрыг эзлэн төрсөн, арван насандаа

					арын харуул даасан Алиа догшин баатар
Сумаа шивших	Шуушилдай мэргэн харвахдаа сумаа шившиж тавьдаг	-	-	-	Алиа догшин баатар сумаа шившин харвадаг
Төгсгөл	Шуушилдай мэргэнд харвуулсны дараа мангас өршөөл эрдэг ч Алтан ноён галуу хүү толгойг нь цавчдаг	Алтан ноён галуу хүү ямар нэгэн баатраас тусламж авалгүй өөрийн хүчээр дийлдэг	Үлдсэн ганц толгойгоороо мангас зугтаана. Мэргэн баатар хүү мангасыг дахин харваад хомхой мангасын гэдсийг ховх цоолон нээдэг.	Уран могой ээж нь мангастай хуйвалдаж хүүгээ алдаг. Бумбат рашаанаа хүүгийн ясан дээр гурвуул дусаасанд Алтан галуу ноён хан хүү дахин амилаад, мангасыг цавчиж, эхийгээ мөн алдаг.	Алиа догшин баатрын орон нутагтаа харьдаг

Хүснэгт 2.

Дээрх хүснэгтээс нэгтгэж үзвэл Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Хөхөөгийн Ичинхорлоогийн аялгуулан хэлсэн “Алтан ноён галуу хүү” тууль, Өвөрхангай аймгийн Дүгэрийн Лүндаажанцангийн тэмдэглүүлсэн “Алтан ноён галуу хүү гэгч үлгэр” хоёр бусад хувилбараа бодоход ойр дөхөм өгүүлэмжтэй байна. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Цэрэнгийн Шаравын 1961 онд хэлж тэмдэглүүлсэн “Зүүн гурван тивийг эзлэн төрсөн Алтан ноён Галуухай хаан” болон Хэнтийн халх Баяны Жанжаагийн тэмдэглүүлсэн “Алтан галуу ноён хан хүү” хувилбарт арван гурван сангаа тавих талаар ижил өгүүлэмж гарч байна. Хэнтийн халх Баяны Жанжаагийн тэмдэглүүлсэн “Алтан галуу ноён хан хүү” хувилбарт мөн ээж нь мангастай хуйвалдсан содон өгүүлэмж илэрч байгаа нь судлуштай. Барнайн Лхамсүрэнгийн үлгэрийн цуглуулгад буй “Алтан галуу ноён” хувилбарт Агь улаан хааны Алтан галуу ноёноос илүү Алиа догшин баатар голлох үүрэгтэй байгаа нь туулийн гол баатрын нэрийг сольж хольсон, эсвэл өөр туулийг ийнхүү нэрлэсэн байх магадлалыг ихэсгэж байна. Энэ мэтчилэн туулийн хувилбаруудыг нарийн ажиглавал өөр өөрсдийн онцлогтой, мөн ижил төстэй үг хэллэг, үйл явдал, газар орон, орчин нөхцөлтэй, түүнээс гадна зөрүүтэй хэдий ч нэг хувилбар нөгөө хувилбараас ашигласныг харж болохоор байна. Үүнд, долоон насандаа долгионхон төрсөн, Дотор Бээжин хоёрыг эзлэнхэн төрсөн Хан Чингис хааны Хар нүдэн авай нь долоон насандаа догдлуулан эхэлсэн, Дотор Бээжин хоёрыг эзлэн төрсөн, арван насандаа арын харуул даасан Алиа догшин баатартай эгээ адил гуншинтай байгааг цааш судлуштай. Халх ардын ихэнх туульд баатрын бага нас, дайн байлдаан, дайсны байдал, албат иргэд, адуу мал, замын саад бэрхшээл зэрэг монгол туульд дүрслэгддэг үндсэн зүйлийг товчхон дүрсэлсэн буюу зарим нь бүр орхигдсон байна³¹. “Алтан галуу ноён” туулийн эдгээр хувилбарт ч баатрын бага нас, дайн байлдаан, дайсны байдал, албат иргэд, адуу мал, замын саад бэрхшээл зэргийг дүрслэлгүй орхигдуулсныг дээрх хүснэгтээс ажиглаж болно.

³¹ Лувсанвандан С, Загдсүрэн У нар., Халх ардын тууль. Ред Хорлоо П. УБ., ШУАХ, 1967. 3т.

Ийнхүү ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Эх хэл бичгийн сан хөмрөг, лабораторид хадгалагдаж буй тайлан, гар бичмэл эх хэрэглэгдэхүүнээс Түшээт хан аймгийн Далай гүнгийн хошуунд холбогдох “Алтан галуу ноён” хэмээх халх туулийн нэгээхэн төлөөллийг бид шүүрдэн үзэж, хувилбаруудынх нь агуулгыг хураангуйлан, өгүүлэмжийг харьцуулснаар уг тууль нь судалгааны үнэт чанараа хадгалсан хэвээр буйг бататгаж буйн илрэл билээ.

Хавсралт

“Алтан ноён галуу хүү” тууль³²

Эрт урьд цагт
Энх мөнхийн үед
Далай ламыг банди байхад
Диван хааныг балчир байхын үед
Сүн далайг шалбааг байхад
Сүмбэр уулыг гүвээ байхын үед
Дан далайн захад
Далан уулын бэлд
Хүрээ номын эхэнд
Хүйтэн хоолойн адагт
Жаран жалгын эхэнд
Жаргалт хоолойн адагт
Арван найман ханатай
Далан найман хэрэмтэй
Давхар ширмэн байшинтай
Арван найман настай л
Алтан ноён галуу хүү гэж
Нэгэн сайн эр байдаг юм л санж гэнэ ээ.
Түүний доод талын өргөө болбол доо
Давтмал мөнгөн туургатай
Хас л зандан ханатай
Татал зандан тоонотой
Өлзий утсан өрхтэй
Түмэн насан үүдтэй
Хөөмөл гуулин шалтай
Хөх магнаг хөшигтэй
Дээд талын хоёр багана нь
Шижир алтан багана
Түүний доод хоёр багана нь
Алтан сувдан багана
Түүний доод хоёр багана
Мөнгөн сувдан багана

Түүний доод хоёр багана
Ган багана, зэс багана
Ийм арван хоёр баганатай л
Нэг сайхан өргөөтэй юм санж гэнэ ээ.
Алтан ноён галуу хүү нэгэн өдөр
Аавындаа оров гэнэ л дээ.
Галуу мэтээр ганганаж
Гар хуруугаа нахилзуулж
Тоодог мэтээр тонголзоод
Толгой бөгсөө нахилзуулж ааваасаа
Миний унадаг сайн морь минь
Альхан чиг адуундаа явдаг билээ
Алдагхан сайн авгай маань
Альхан зүгтээ суудаг бол оо гэж л
Асуув гэнэ.
Ээ, хүүгийн минь унадаг сайн морь нь
Хойш нь тавьсан
Хорин түмэн адуунд нь
Хуйваар барьдаггүй
Хурайлж нэгэн
Даллаж нэгэн барьдаг
Ам цагаан хул морь бий.
Алдагхан сайн авгай чинь
Долоон насандаа
Долгилонхон төрсөн
Дотор Бээжин хоёрыг
Эзлэнхэн төрсөн
Гурван төрлөө мэдэх
Гундан ягаан хацартай
Туурга нэвт туяарсан
Тунсаг ягаан хацартай
Гэр нэвт гэрэлтсэн
Гэрэл ягаан хацартай
Хан Чингис хааны
Хар нүдэн авайг авна гэж
Морин толгойн чинээ
Молор эрдэнээр

³² Эх хэл бичгийн сан хөмрөг. Соронзон хальс 42a-1.

*Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын “Саруул зам” нэгдлийн 3-р бригадын харьяат 54 настай эмэгтэй Хөхөөгийн буюу Бурамын Ичинхорлоо гуайн аялгуулан хэлсэн “Алтан ноён галуу хүү” туулийг Хэл зохиолын хүрээлэнгийн соронзон хальсны хөмрөгөөс зөвшөөрөл бичгийн дагуу кирилл бичигт буулган хавсаргалаа.

Өндгөн сүй тавьсаар
Тавин найман он боллоо
Одоо л авах л цаг л үе болоод байна гэж л
хэлэв гэнэ л дээ.
Гараад
Наян лангийн хазаараар
Хурайлж нэгэн
Даллаж нэгэн байсан
Хойш нь тавьсан
Хорин түмэн адуунаас нь
Ам цагаан хул морь
Олон адуунаасаа онцгойрон
Хэсэг адуунаасаа хэлтгийрэн
Цөөн адуунаасаа цөмцийж
Сүүл юугаараа тоглож
Сүүдэр юунаасаа бусгаж
Толгой юугаараа тоглож
Тоос юунаасаа бусгаж
Давхиж ирээд
Их л ангайж өгөв гэнэ л дээ.
Алтан мөнгөн шон дээрээ
Авчирч уяад
Ес хоног гэртээ суув гэнэ л дээ.
Аав нь нэгэн өдөр орж ирэв гэнэ.
Хүү минь
Мордов л морд
Мордохгүй юм болбол
Морио тавь
Эр хүн их л гэртээ суувал
Эм шинжийг олдог юм
Эр морийг их л уявал
Гүү шинжийг олдог юм гэж л хэлэв гэнэ л
дээ.
Гараад морио хараалж нэгэн
Зогсож нэгэн байсанд
Тойрсонхон газар нь
Тохой худаг
Эргэсэн газар нь
Эрэг тохой болсон байв гэнэ.
Дахиад нэгэн сайн тойрон шинжсэнд

Алтан сувдан дэлтэй
Мөнгөн сувдан сүүлтэй
Согоо хоёр чихтэй
Цолмон хоёр нүдтэй
Ган ширмэн туруутай
Гавал эрдэнэ толгойтой
Төө сөөм уруултай
Төхмийн их л гэдэстэй
Хатан хонгио хамартай
Харанхуй жалган амтай
Хоёр улаан суганаас нь
Алтан тогосын өд
Гялалзан байхыг нэгэн үзэв гэнэ л дээ.
Хүний ясаар
Хүрээлэнхэн хийсэн
Хөтлийн чинээ
Хүрэн зандан эмээлийг
Нуруу юунд нь тааруулж
Далан лангийн ташуурыг
Дал хаанд нь тааруулж
Дөчин лангийн дөрөөг
Дөрвөн өндөрт нь тааруулж
Зуун лангийн хударгыг
Зураа юунд нь тааруулж
Наран саран гөлөм нь
Наана цаанаа намина гэнэ.
Нарийн найман ганзага нь
Дөрвөн талдаа намина гэнэ.
Эргээд нэгэн харав гэнэ
Эвтэй сайхан таарав гэнэ л дээ.
Тойрон нэгэн харав л гэнэ
Тавтай сайхан таарав гэнэ.
Мордоод баруун тивийг бариуланхан нэгэн
тавьж үзэв гэнэ.
Баруун талын үүл нь
Баруун тийшээ нүүгээд
Барс шаазгай шагшралдаад
Хүүхэдтэй авгай
Хүүхдээ орхин уйлан дагаж
Тугалтай үнээ

Тугалаа орхин мөөрөн гүйж
Ботготой ингэ нь
Ботгоо орхин буйлан дагаж
Хүүхэдтэй хүүхэн
Хүүхдээ орхин уйлан дагав.
Зүүн тийш нь эргүүлээд
Зүүн тивийг бариуланхан нэгэн тавьж үзэв
гэнэ.
Зүүн талын үүл нь
Зүүн тийшээ нүүгээд
Зүр шаазгай шагшралдаад
Айлаар хүмүүн уйлалдаад
Агтаар адуу нь унгалдаад
Зэлээр үхэр мөөрөлдөөд
Зэргийн тэмээ буйлалдаад
Хотоор хонь нь майлалдаад
Хотын маймаа шуугилдаад байв гэнэ.
Хойш нь эргүүлээд
Алтан сувдан дэлээр нь
Хурмаст тэнгэрийг бүрхүүлээд
Мөнгөн сувдан сүүлээр нь
Замбуутивийг бүрхүүлээд
Төв сайхан духыг нь
Дөтийн нуруу чиглүүлээд
Согоо хоёр чихийг нь ээ
Алсын уулыг чиглүүлж
Цолмон хоёр нүдийг нь ээ
Тэнгэрийн агаар чиглүүлээд
Жир жирхэн хатиргаад
Жингэнэтэл исгэрээд л
Давхиулж л явуулж нэгэн байв л гэнэ л дээ.
Оосор ч үгүй бүч ч үгүй
Орд цагаан өргөө нэгэн байв гэнэ.
Гадаа нь очоод нохой хорь гэсэн
Хатан бололтой нэгэн хүмүүн
Гараад ирэв гэнэ.
Морио хана мэтээр хантайруулж
Хайрцаг мэтээр тушаад орсон
Хаан бололтой нэгэн хүмүүн суув гэнэ
Хаан бугай та амар байна уу?

Хатан бугай та мэнд байна уу? гэж л хэлэв.
Мэнд байна
Мэнд байна уу? хүү минь
Нүүрэндээ галтай
Нүдэндээ цогтой
Шилэндээ шилтэй
Шилбэндээ чөмөгтэй
Бяцхан хар хүү минь ээ
Хэн хүний нь үр билээ
Хэтийн зориг хэнд билээ
Хэтийн нутаг хаана билээ
Аль хүний үр билээ
Алсын зориг хэнд билээ? гэж л
Асуув гэнэ л дээ.
Би дан далайн зах дээр
Далан уулын бэл дээр
Хүрээ номын эхэнд ээ
Хүйтэн хоолойн адагт
Жаран жалгын эхэнд
Жаргалт хоолойн адагт
Арван найман ханатай
Далан найман хэрэмтэй
Давхар ширмэн байшинтай
Арван найман настай
Алтан ноён галуу хүү гэдэг байна.
Долоохон насандаа
Долгилонхон төрсөн
Дотор Бээжин хоёрыг
Эзлэнхэн төрсөн
Гурван төрлөө мэдэх
Гундан ягаан хацартай
Туурга нэвт туяарсан
Тунсаг ягаан хацартай
Гэр нэвт гэрэлтсэн
Гэрэл ягаан хацартай
Хан Чингис хааны
Хар нүдэн авайг авна гэж
Морин толгойн чинээ
Молор эрдэнээр
Өндгөн сүй тавьсаар

Тавин найман он боллоо
Одоо л авах цаг үе болоод байна гэж л явна
даа гэж л хэлэв гэнэ л дээ.
Ээ, хүүгээс минь өмнөхөн
Тэмээн чинээ толгойтой
Тивийн чинээ залаатай
Дошийн чинээ малгайтай
Тавгийн чинээ нүдтэй
Том хар мангас аваад явчихна лээ гэж хэлэв
гэнэ л дээ.
Ноён эхтэй л намайг байхад
Нохойн гөлөг мангаст юунд өгөв?
Хан эхтэй л намайг байхад
Хар нохойн гөлөг мангаст юунд өгөв?
Хаашаа л явав? гэж хэлээд
Мордох гэж гэнэ.
Хаан хойшоо эргэв гэнэ
Хойд талын авдрыг түлхэж
Арван лангийн шунхан алтыг
Алд дэлэм хадагтай л
Хүү минь
Дайнаа сайн дараарай
Дархан цолыг олоорой
Өстнөө дараарай
Өргөн цолыг олоорой гэж хэлээд
Барьж өгөв гэнэ л дээ.
Арван лангийн шунхан алтыг нь
Адис аваад бурханд нь тавиад
Алд дэлэм хадгийг нь
Өвөртлөөд мордов гэнэ.
Төв сайхан духыг нь
Дөтийн нуруу чиглүүлж
Согоо хоёр чихийг нь
Алсын уулыг чиглүүлээд
Цолмон хоёр нүдийг нь
Тэнгэрийн агаар чиглүүлж
Жир жирхэн хатиргаад
Жингэнэтэл исгэрээд л
Давхиулж нэгэн явуулж нэгэн байв л гэнэ.
Баруухан талын лусын хаадыг

Түшүүлэнхэн барьсан
Зүүхэн талын хурмаст тэнгэрийг
Түшүүлэнхэн барьсан
Нэг л их том цагаан гэр л байв л гэнэ л дээ.
Тоонон дээр нь очоод
Алтан бялзуухай болон суугаад харав гэнэ л
дээ.
Тэмээн чинээ толгойтой
Тивийн чинээ залаатай
Дошийн чинээ малгайтай
Тавгийн чинээ нүдтэй
Том хар мангас
Баруун хойд талаа
Эзлэнхэн суучхаад
Барын чинээ
Бараан гуяыг
Нэгэн хоёр алгадаад
Бар бар инээд алдаж сууна гэнэ л дээ.
Хан Чингис хааны
Хар нүдэн авай
Зүүхэн урд талыг нь
Эзлэнхэн суучхаад
Энтэй торгыг шаглаж
Энгүй торгыг захалж сууна гэнэ л дээ.
Хатан дээшээ хараад
Инээд алдаж сууна гэнэ.
Чи хоёулхнаа сууж байгаад
Юунд чиний инээд чинь хүрээ билээ?
Овтон эмийн ов нь хөдлөө юу?
Живтэн эмийн жив нь хөдлөө юу? гэж хэлэв
гэнэ л дээ.
Би овлохдоо ч яагаа вэ?
Живлэхдээ ч яагаа вэ?
Халхад сайн эр байдаг болов уу? гэж
Инээд хүрч байна гэж л хэлэв гэнэ.
Халхад надаас сайн эр байхгүй
Арван найман настай
Алтан ноён галуу хүү гэдэг
Надаас ганцхан хэрчим илүү гэж л суув гэнэ.
Алтан ноён галуу хүүгийн

Уур нь хүрэв гэнэ	Ойроос ирснээрээ
Уушги зүрх нь сагсайв гэнэ л дээ.	Би түрүү харвах уу?
Орой дээрээсээ	Холоос ирснээрээ
Очирваань залруулаад	Чи түрүү харвах уу? гэж л асуув гэнэ л дээ.
Зулай дээрээсээ	Ойроос ирснээрээ
Зонхов бурхан залруулаад	Чи түрүү харва гэж хэлээд
Магнай дээрээсээ	Болзоотын бор толгой дээрээс
Махгал бурхан залруулж	Алтан ноён галуу хүү
Түмэн лууны дуу шиг	Мянган хонины хотын чинээ
Түрчигнэнхэн дуугарч	Цагаан хэнхдэгийг дэлгэж
Мянган лууны дуу шиг	Шүдлэн үхрийн чинээ
Начигнанхан нэгэн дуугарч	Цагаан гуяыг түгжиж өгөв гэнэ л дээ.
Түмэн хүн айх	Мангас уулзахын улаан хөтөл дээрээсээ
Түүхий улаан царайгаа гаргаад	Шээзгийн чинээ
Орж нэгэн очив гэнэ.	Ширмэн булцуут
Хар нохойн гөлөг мангас чи	Даргай хар нумыг л
Амар байна уу?	Өглөөний өөд улаан наранд татаад
Хатан бугай та	Оройн жаргах улаан наранд
Мэнд байна уу?	Артыг арлуулж
Ноён эхтэй л намайг байхад	Өвөртийг өвөрлүүлж
Нохойн гөлөг чи юунд авав?	Хонин чинээ цагаан чулууг
Хан эхтэй намайг байхад	Хог тэмдэггүй болгож
Хар нохойн гөлөг мангас чи юунд авав? гэж	Үхрийн чинээ улаан чулууг
Ган иштэй эрээн илдийг л	Үртэс тэмдэггүй болгож тавина гэнэ.
Түрийндээ нийлж	Алтан ноён галуу хүүд
Түнхэндээ нулимж очив гэнэ.	Сум нь хүрэхдээ
Чи нүүрэндээ галтай	Хүрэн улаан
Нүдэндээ цогтой	Гарахдаа
Шилэндээ шилтэй	Ган улаан болж
Шилбэндээ чөмөгтэй	Алтан ноён галуу хүүгийн
Бузгай л хар хүү бол хө	Цээжин дээр нь бууна гэнэ.
Маргаашийн мандах улаан наранд	Яс оносон юм шиг
Уулзахын улаан хөтөл	Ян хийж
Болзоотын бор толгой хоёрт	Хад оносон юм шиг
Улаан цайгаа уулцъя	Хан хийж байхыг үзнэ гэнэ.
Аль л дийлсэн нь авъя гэж л хэлэв гэнэ л дээ.	Одоо муу дүүгийн чинь тавих ч ээлж болов
За тэгье гэж хэлээд	уу даа гэж хэлээд
Болзоотын бор толгойд гарч	Уулзахын улаан хөтөлд гарав гэнэ.
Мангас мандах улаан наранд	Мангас болзоотын бор толгой дээрээс
Уулзахын улаан хөтөлд гарч ирэв гэнэ л дээ.	Зуун хонины хотын чинээ

Бараан хэнхдэгийг дэлгэж өгөв гэнэ
Барын чинээ
Бараан гуяыг түгжиж өгөв гэнэ л дээ.
Алтан ноён галуу хүү нь
Уулзахын улаан хөтөл дээрээс
Хандгай бугын ширийг
Ханзлал үгүй хийсэн
Хангардийн өдийг
Таслал үгүй тавьсан
Даргай хар нумыг
Өглөөний өөд улаан наранд татаад
Оройн жаргах улаан наранд
Артыг арлуулж
Өвөртийг өвөрлүүлж
Хонин чинээ цагаан чулууг нь
Хог тэмдэггүй болгож
Үхрийн чинээ улаан чулууг нь
Үртэс тэмдэггүй болгож
Мангаст хүрэхдээ
Хүрэн улаан
Гарахдаа
Ган улаан болж
Мангасыг цээж бөгсөлнө гэнэ л дээ.
Мангас хойд уулаа авч
Хойд сорвио бөглөчхөөд
Урд уулаа авч
Урд сорвио бөглөчхөөд
Хар хадгаар
Хав хийтэл нь ороочхоод
Шар хадгаар
Шав хийтэл нь ороочхоод
Өмнөө байсан уулаар
Тэвэг өшиглөнхөн
Айсуй байхыг үзэв гэнэ л дээ.
Алтан ноён галуу хүү нь
Одоо энийг чинь ядаг юм билээ гэж
Ард нь малгай мэт навтганаж
Өвөрт нь хачиг мэт бүртгэнэж байв гэнэ.
Алтан ноён галуу хүүгийн
Орон нутагт

Ээж нь аав нь хоёр нь нэгэн шөнө
Зүүдлэн хонов гэнэ л дээ.
Миний хүү
Орон дээрээс шилжиж
Олбог дээрээс гулгаж
Ширээн дээрээс шилжжээ
Ширдэг дээрээс гулгажээ гэж
Зүүдлэн хонов гэнэ
Ахад нь хэлэв гэнэ.
Ах нь Уушилдай хүү
Шуушилдай мэргэн
Гомбо начин чогдон баатар гэж
Нэг сайн эр байв гэнэ.
Ах нь дээл ч үгүй, өмд цамцтай
Хазаар ч үгүй, ногттой
Эмээл ч үгүй зайдан
Тавин хоёр хурдан цагаан сумаа аваад
Болзоотын бор толгойд гарав гэнэ.
Саравчлан харж
Сарын газар харж
Жилэвчлэн харав
Жилийн газар харав гэнэ.
Тээр тэр
Гурван жилийн тэртээ л
Үүл гэтэл үүл биш
Уул гэтэл уул биш
Нэг л их л юм байв гэнэ.
Мангасын амин газраар орох болтугай
Миний дүүгийн амь нь гарахгүй болтугай
гэж хэлээд
Шившээд харвасан нь
Мангасын амин газраар оров гэнэ л дээ.
Хойд уулыг дэрлэж
Дунд уулыг дамнаж
Урд уулыг жийж
Гарын хумс
Гадаа тийшээ гажиж
Ган төмөр дэгээ болж
Хөлийн хумс
Хөдөө тийшээ гажиж

Хөх төмөр дэгээ болон
Ойчив гэнэ.
Алтан ноён галуу хүү нь
Ган иштэй эрээн илдийг л
Түрийндээ нийлж
Түнхэндээ нулимж чичилж
Эр хүн
Эр хүндээ хайртай
Эр морь нь
Эмээл хазаартаа хайртай
Алтан амийг
Аварч өршөө
Аргал түлшийг чинь түүж
Адуу малыг чинь хариулъя
Албат хэргийг чинь гүйцэтгэе
Алтан амийг
Аварч өршөө гэж
Мангас гуйв гэнэ.
Аавын төлгөнд үзсэн
Амьхан дор нь
Ал гэж байна
Ээжийн төлгөнд үзсэн
Энэхэн дор нь
Эвд гэж байна гэж хэлээд
Толгойг нь тас цавчиж аваад
Мориндоо молцог хийгээд
Мордов гэнэ.
Гэрт нь очоод
Ямаан бүрээгий нь татаж
Ямбатай бүгдийг нь цуглуулаад
Бүдүүн бүрээгий нь татаж
Бүгдээрэнг нь цуглуулаад
Тэмээн бүрээгий нь татаж
Тэмдэгтэй бүгдийг нь цуглуулаад
Хөрөнгө мал
Хөөтэй шилээвэр
Хөгнийн товч хүртэл
Хурааж аваад
Орон нутагтаа харив гэнэ.
Дайнаа дарав гэнэ

Дархан цолыг олов гэнэ.
Өстнөө дарав гэнэ
Өргөн цолыг олов гэнэ.
Хорин жилийн хурим хийгээд
Жаран жилийн жаргал хийгээд
Наян жилийн найр хийгээд
Амар сайхандаа жаргаж байв гэнэ ээ³³.

³³ Уг туулийн соронзон хальсны бичлэгийг сонсож, кирилл бичигт буулгахдаа Хэл зохиолын хүрээлэнгээс 1991 онд хэвлүүлсэн “Халх ардын тууль” болон 2013 оны “Халх тууль” номд орсон “Алтан ноён галуу хүү” туулийн сэлбэж нэгтгэсэн эхтэй харьцуулж, мөн хөмрөгийн 173 дугаар хавтаст материалд Хөхөөгийн Ичинхорлоо гуайн аялгуулан хэлсэн “Алтан галуу ноён” туулийг буулгасан гар бичмэл хадгалагдаж байсантай тулган үзэж, хэд хэд сонсон нягталсны эцэст бид энэхүү илтгэлдээ хэл найруулгад нь засвар оруулалгүй, ямар нэгэн байдлаар нэмж, таналгүйгээр яг эх хувиар нь буулган хавсарган орууллаа.

Гар бичмэлийн хавсралт

1. Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын Хөхөөгийн Ичинхорлоогийн 1973 онд аялгуулан хэлсэн “Алтан ноён галуу хүү” туулийн гар бичмэлээс

29 Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын
 “саруул зам” нэгдлийн “Хөх Өвөөн Гүя”
 бригад Бурхан Ичинхорлоогийн эмч нас 54
 Алтан Галуу Ноён Хүү (цугар)

эрт урьдын цагаар
 энх шонжийн үед
 далай намьст Банди байжар
 даян хаант байжар байжар
 суун далайг шалбаат байжар
 сүлбэр уулын цувра байжар
 дан далайг захад
 далай уулын бэлдэнэ.
 Хүйн Амьсн эхэнд
 хүдэн, хөвдөн адал
 таран малын эхэнд
 маргалт холмог адал
 Арван Найман ханарай
 далан Найман хэрэмрэй.
 Давхар ширмэн байшинтай
 Арван Найман настай
 Алтан Ноён Галуу Хүү гэж
 нэгэн сайн эр байвас
 Түүний доогуу талын өргөө байв
 Давхар, монгол туургаарай
 Ясн занган ханарай
 Гасил занган тоонотой

49 -21- 050310039
 Хорин жилийн Хурин Хийлгээг
 таран жилийн маргалт Хийлгээг
 Нэгэн жилийн Нэгэр Хийлгээг
 Ямар Сайжардаа маргалт
 байв гэнэ!
 1973-7-30

“ ”
 Давхарын 3р Давхарын 2р
 Талын Хөх Галууны байр.
 Өв. Дэлгэрхаан,
 Агуурын Хэр Цулуу.

2. Өвөрхангай аймгийн Дүгэрийн Лүндаажанцангийн тэмдэглүүлсэн “Алтан ноён галуу хүү гэгч үлгэр”-ийн гар бичмэлээс

959 026200039 92

Handwritten text in vertical columns, likely a legend or list of characters for the story "The Legend of Golden Son".

